



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 03 -ны өдөр

Дугаар 1/09

Эрдэнэт

Тандалтын багийн бүрэлдэхүүнийг
томилох тухай


Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай" 527 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Тандалтын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тандалтын багийн гүйцэтгэх үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн халдварт өвчний хам шинж, сэжигтэй тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ, тандалт судалгаа хийж, эргэн мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллахыг багийн ахлагч, гишүүдэд даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 02 дүгээр сарын
03.-ний өдрийн 1/09 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



Багийн ахлагч: Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

Орчны эрүүл мэндийн тандалт, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн


БОЭТ-ийн лабораторийн эрхлэгч

БОЭТ-ийн лаборант

Дархлаажуулалт, зоонозын асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг: Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 04 дугаар сарын
05.-ний өдрийн 1109 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ТАНДАЛТЫН БАГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

1. Аймгийн хэмжээнд тандалтын тогтолцоонд хамрагдах эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг ХӨСҮТ-ийн Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээний нэгжтэй хамтран гаргаж, эрүүл мэндийн байгууллага бүрт тандалт хариуцсан орон тооны бус мэргэжилтнийг ажиллуулан, арга зүйгээр ханган ажиллана.
2. Даваа гараг бүр эрүүл мэндийн байгууллагаас халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлын мэдээг мэдээлэх хуудсын дагуу эпидмиологийн долоо хоногоор авна. /Эпидмиологийн долоо хоногт Бямба гарагаас Баасан гарагийг дуустлах долоо хоногийг хамруулна/
3. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээнд дүн шинжилгээ хийж, Мягмар гараг бүр цахим хаяг (www.ewar@nccd.gov.mn) -аар ХӨСҮТ-ийн Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээний нэгжид мэдээлнэ.
4. Халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдол нь яаралтай мэдээлэх босго үзүүлэлтэд хүрсэн тохиолдолд ХӨСҮТ-ийн Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээний нэгжийн 11-455388 тоот утас, цахим хаяг (www.ewar@nccd.gov.mn) –аар яаралтай мэдээлнэ.
5. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлын мэдээлэлд долоо хоног тутамд дүн шинжилгээ хийж, эргэн мэдээллээр хангана.
6. Дэгдэлтийн үед холбогдох мэргэжлийн багтай хамтран хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тандалт судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
7. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын 20-30%-д үйл ажиллагааны дэмжлэгт болон явцын хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангана
8. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын тандалт хариуцсан мэргэжилтнүүдийг ХӨСҮТ-ийн Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээний нэгжтэй хамтран тасралтгүй сургалтад хамруулна.